

ӨРШӨӨЛ ҮЗҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ПРАКТИКИЙН АСУУДАЛД



Н.ГАНТУЛГА

*Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн
сургуулийн захирал, доктор
/Ph.D/, дэд профессор, хурандаа*



Н.БАТДОРЖ

*Ахлагчийн сургуулийн ахлах багш,
хууль зүйн магистр, хошууч*

УИХ-ын гишүүн Л.Цог, Д.Ганбат, Б.Батэрдэнэ, Ц.Оюунбаатар нарын 20 гаруй гишүүд хамтран “Өршөөл үзүүлэх тухай” хуулийн төслийг санаачлан 2013 оны 10 дугаар сарын 10-ны өдөр УИХ-ын дэд даргад өргөн мэдүүлж төслийн талаар олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэдэнтээ тайлбарлаж байсныг олон хүн мартаагүй, магадгүй цөөнгүй хүмүүс (ялангуяа ял эдлэгсэд, хэрэг нь хянан шийдвэрлэх шатанд байгаа хүмүүс, тэдний ар гэрийнхэн зэрэг) найдлага тавин хүлээсээр байхыг үгүйсгэхгүй.

Монгол Улсын Үндсэн хуулийн 25-р зүйлийн 1 хэсэгт: “Улсын Их Хурал ... дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ: 14) *өршөөл үзүүлэх шийдвэр гаргах*”, 26-р зүйлийн 1 хэсэгт “Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүн,



Засгийн Газар хууль санаачлах эрх эдэлнэ” гэж хуульчилсан ба энэ зохицуулалт хүчин

төгөлдөр хэвээр тул өршөөлийн хуулийн асуудал нээлттэй байгаа гэж үзэж болно.

Дээр дурьдсан санаачлагчдын олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд өгч байсан мэдээний тоймд анализ хийн үзвэл өршөөлийн хуулийн төслийн онцлогт доорхи зүйлсийг хамруулж болно. Энэ нь:

- Өмнө нь Өршөөлийн тухай хуулийг УИХ (өмнөх тогтолцооны үед “Ардын Их Хурал”), Ерөнхийлөгч, Засгийн Газраас санаачлан өргөн мэдүүлдэг байсан бол энэ удаад УИХ-ын 20 гаруй гишүүд хамтран төслийг санаачилж өргөн мэдүүлсэн.

- 2009 оноос хойш Монгол улсад Өршөөлийн тухай хууль батлагдаагүй ба өнөөдөр мөрдөгдөж буй эрүүгийн хуулийн ялын бодлого “хатуу-чанга” хэмээн хүний эрхийн чиглэлээр мэргэшсэн судлаачид, иргэний нийгмийн төлөөлөл, тэрчлэн засгийн эрх баригч улс төрийн хүчин хүлээн зөвшөөрдөг тул зарим ялтнуудад өршөөл үзүүлэх нь зохих үр дүнгээ өгнө гэж Засгийн газрын хуралдаанаар үзэн төслийг дэмжиж саналаа өгсөн.

- Өршөөлийн тухай энэ удаагийн хуулийн төслийг боловсруулахад парламентад суудалтай бүх улс төрийн хүчин, бие даагчдын төлөөлөл оролцсоны зэрэгцээ хүний эрх, эрүүгийн хууль тогтоомж, практик судлалаар мэргэшсэн судлаачид, их дээд сургуулийн эрдэмтэн багш нар оролцсоны гадна Улсын Дээд Шүүх, Хүний Эрхийн Үндэсний комисс, Улсын Ерөнхий прокурорын газар зэрэг Үндсэн хуулийн байгууллагуудаас ирүүлсэн саналыг төсөлд өргөнөөр тусгахыг эрмэлзжээ.

- Мөн хууль санаачлагчид өмнө нь гарч байсан Өршөөлийн хуулиудын давуу, сөрөг талуудыг хянан тооцсоны зэрэгцээ ялтан хохирлоо бүрэн барагдуулсан байх,

хүн нэг бүр бичгээр амлалт үүрэг авах зэрэг шинэ зохицуулалтыг төсөлд тусгасан, түүнчлэн суллагдах ялтныг ажлын байраар хангах, тэдэнд бусад дэмжлэг туслалцаа үзүүлэхэд чиглэсэн зохион багуулалтын ажлуудыг ч тооцон хийж эхэлсэн байна.

Гэвч олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүн амд хүрч буй сүүлийн үеийн мэдээллээс үзвэл Өршөөлийн тухай хуулийн төслийг “царцааж” Гэмт хэргийн тухай хуулийн төслийг батлан хэрэгжүүлэх хүрээнд асуудлыг нэгтгэн шийдвэрлэхээр төр засгийн бодлого-чиглэл гарсан гэж үзэх үндэслэлтэй байна.

Иймд энэ чиглэлийн судалгааны ажилд бага боловч хувь нэмэрээ оруулах, мөн цаашдын хэлэлцүүлгийн объект болгон эрдэм судлалын ажлыг өрнүүлэх зорилгоор манай хөрш ОХУ энэ асуудалд хэрхэн хандаж, шийдвэрлэж буй практикийн талаархи мэдээллийг хүргэхээр ОХУ-ын Ял эдлүүлэх Холбооны албанаас эрхлэн гаргадаг “Гэмт хэрэг, ял шийтгэл” сэтгүүлийн 2014 оны №1 дугаарт хэвлэгдсэн “Өршөөл зарлагдлаа” нийтлэлийг, мөн өршөөлийн тогтоолтой холбогдсон зарим судлаачдын байр суурийг зохиомжлон, харин “Российская газета” сонины 2013 оны 12-р сарын 19-ны дугаарт хэвлэгдсэн “ОХУ-ын Үндсэн хууль батлагдсаны 20 жилийн ойтой уялдуулан Өршөөл зарлах тухай” Төрийн Думын 2013 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн №3500-6 ГД тогтоолыг тус тус албан бус байдлаар хөрвүүлэн хүргэж байна.

ӨРШӨӨЛ ЗАРЛАГДЛАА!

ОХУ-ын Төрийн Думд өргөн баригдсан хуулийн зарим төслүүд хэлэлцэгдэлгүй удааширдаг. Доод танхим

ажлын хангалттай шахуу хуваарьтай ч олон баримт бичиг, хуулийн төслүүд тодорхой шалтгааны улмаас хэлэлцэх хугацаа нь хойшлогддог.

Гэвч өнгөрсөн оны 12 дугаар сарын 09-нд ОХУ-ын ерөнхийлөгч Владимир Путины өргөн мэдүүлсэн хуулийн төслийг депутатууд шинэ оны амралтын өдрүүдээс өмнө батлахыг амалж түүнийгээ биелүүлэн Төрийн Дум 2013 оны 12-р сарын 18-ны өдөр ОХУ-ын Үндсэн хуулийг баталсаны 20 жилийн ойтой уялдуулан Өршөөлийн тухай тогтоолыг баталсан.

Зарим ялтнуудад өршөөл үзүүлэх шаардлагын тухай яриа хэлэлцүүлэг эрт яригдан эхэлсэн ба 2013 оны зун эдийн засгийн зарим гэмт хэргийн төлөө хорих ял эдлэж буй хүмүүсийг суллах шийдвэр гарч түүнд 300 орчим ялтан хамрагдсан.

Гэвч өмгөөлөгчид, хүний эрхийн төлөө тэмцэгчид, хорих ял эдлэгсдийн тоог бууруулахын төлөө үйл ажиллагаагаа чиглүүлэгч олон нийтийн зүтгэлтнүүд дээрх шийдвэрт сэтгэл хангалуун бус байсан тул ОХУ-ын Үндсэн хууль батлагдсаны 20 жилийн ойтой уялдуулан Өршөөл үзүүлэх баримт бичгийн төсөл боловсрогдож эхэлсэн.

Энэ ажилд парламентад суудалтай хэд хэдэн намын төлөөлөгчид хамрагдсан боловч ард түмний элч-депутатууд эцсийн дүндээ төрийн тэргүүний өргөн мэдүүлсэн



төслийг хэлэлцэхээр шийдвэрлэсэн. Төслийн давуу байдлыг сөрөг хүчний депутатууд ч “илүү энэрэнгүй” хэмээн хүлээн зөвшөөрсөн.

2013 оны 12-р сарын 16-ны өдөр Төрийн Думын Иргэн, Эрүүгийн хууль тогтоомжийн асуудлаар Мэргэшсэн Хороо Владимир Путины санал болгосон баримт бичгийг хэлэлцсэн ба зарим депутатуудын зүгээс 12-р сарын 23-наас өмнө энэ төслийг танхимын 3 удаагийн хэлэлцүүлгээр баталж амжихгүй талаар сэтгэл зовинож саналаа илэрхийлж байсан боловч асуудал нааштайгаар шийдвэрлэгдэн зохих Хорооноос 12-р сарын 17-ны өдөр төслийг санал хураалтад шилжүүлэн, дараагийн өдөр нь журмын дагуу бусад үе шатууд явагдаж тогтоолын төслийг парламентын доод танхимын депутатууд санал нэгтэй баталсан.

ОХУ-ын Үндсэн хуулийн дагуу өршөөлийн тухай тогтоолыг батлах асуудал Төрийн Думын онцгой бүрэн эрхэд хамаардаг учир парламентын дээд танхим-Холбооны Зөвлөлийн зүгээс хэлэлцэн баталгаажуулах шаардлага байхгүй. Иймээс 12-р сарын 18-ны өдөр тогтоол батлагдаж улмаар Өршөөлд 25 мянга орчим хүн хамрагдсан юм.

Өршөөлийн тогтоолоос үзвэл ялаас чөлөөлөгдсөн хүмүүсийн ихэнх нь нийгмийн хамгааллын хувьд эмзэг бүдэгт хамаарах иргэд байв. Тухайлбал: Насанд хүрээгүй байхдаа гэмт хэрэг үйлдэж шийтгэгдсэн, насанд хүрээгүй хүүхэдтэй эмэгтэйчүүд, жирэмсэн эмэгтэйчүүд, тэтгэвэрийн насныхан, тахир дутуугийн 1, 2-р групптэй, Чернобылийн атомын цахилгаан станцын ослын үр дагаврыг арилгах ажиллагаанд оролцсон иргэд, түүнчлэн цэргийн алба хаагчид, хууль сахиулах байгууллагын ажилтнууд, зэвсэгт тэмцэл

болон эх орноо хамгаалах үйлсэд оролцогчид тус тус болно.

Ер нь өршөөлд зөвхөн анх удаагийн ял шийтгэлтэй, шүүхээс оногдуулсан хорих ялын хугацаа нь 5 жилээс хэтрэхгүй хүмүүс л хамрагдсан. Мөн Тогтоолын үйлчлэлд хэрэг хянан шийдвэрлэх байгууллагуудад эрүүгийн хэрэг үүсгэгдэн шалгагдаж буй зарим иргэд хамрагдсан.

Харин өршөөлийн хуульд хугацаанаасаа өмнө хорих газраас суллагдсан, өршөөлд өмнө нь хамрагдаж байсан, хорих байгууллагад ял эдлэх хугацаандаа дахин гэмт хэрэг үйлдсэн, ял эдлэх журмыг ноцтой зөрчигч хоригдлууд хамрагдаагүй. Түүнчлэн 5-аас бага жилийн хорих ялтай боловч дараах гэмт хэргийг үйлдсэний учир ял эдлэгсдэд өршөөлийн тогтоолын үйлчлэл хамраагүй. Энэ нь: ОХУ-ын Эрүүгийн хуулийн 133-р зүйл /“Бэлэгсийн шинж чанартай үйлдэлд албадах”/, 205-3 зүйл /“Террорист үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор сургалтад хамрагдах”/, 205-4 зүйл /“Террорист нийгэмлэгийг зохион байгуулах, түүнд оролцох”/, 205-5 зүйл /“Террорист байгууллагын үйл ажиллагааг зохион байгуулах, тийм байгууллагын үйл ажиллагаанд оролцох”/, 286-р зүйлийн 3-р хэсгийн “а” заалт /Хүч хэрэглэх эсвэл түүнийг хэрэглэхээр заналхийлэн албан тушаалын эрх хэмжээгээ хэтрүүлэх/ тус тус болно.

Өршөөлийн тогтоол батлагдан үйлчлэлд нь хамрагдах этгээдүүдийн хүрээ тогтоогдсоноор хорих байгууллагуудын алба хаагчдын ажил эхэлсэн. Учир нь хорих ял эдлэгсдийн харьцаанд тогтоолын гүйцэтгэлийг хангах арга хэмжээ прокурорын баталсан Засан хүмүүжүүлэх байгууллага, Цагдан хорих байр, Эрүүгийн

ял шийтгэлийг гүйцэтгэх инспекц /хороо/-үүдийн даргын тогтоолоор хэрэгжиж эхэлсэн.

Аливаа ялтанд өршөөл үзүүлэх тогтоолыг хэрэглэсэн баримт бичигт түүний хувийн хэрэг, сайшаал-урамшуулал, шийтгэлийн тодорхойлолтууд болон бусад бичиг баримтууд хавсаргагдсан.

Тэнсэн харгалзах ялтай, хорих ялын хугацааг хойшлуулсан ялтнуудыг шүүхийн шийдвэрийн дагуу өршөөлд хамруулан тогтоолыг хэрэглэжээ.

Үүнээс гадна тодорхой ялтны хувьд зайлшгүй шаардлагатай бөгөөд тухайн цаг хугацаанд байхгүй байгаа баримт бичгийг өршөөлийн тогтоолын гүйцэтгэлийг хангах байгууллагууд зохих байгууллагуудаас шаардах эрхээр, нөгөө талаас холбогдох этгээдүүд түүнийг нь нэн даруй гаргаж өгөх үүргийг хүлээлгэсэн учир асуудал богино хугацаанд шийдвэрлэгджээ.

ӨРШӨӨЛИЙН ТОГТООЛЫН ТАЛААРХИ СУДЛААЧДЫН БАЙР СУУРЬ



Борис Алексеевич
Сушков
Эрүүгийн ял эдлүүлэх
системийн
Халамжийн
зөвлөлийн гүйцэтгэх
захирал

Миний хувьд Өршөөлийн тогтоол зохих үүргээ гүйцэтгэсэн гэж үздэг. Учир нь тогтоол нийгмийн чиг баримжааг эрхэмлэн илүү “дундаж” хувилбар байж оросын иргэдийн гэмт хэрэгтнүүдэд хандах бодит хандлагыг илэрхийлсэн юм. Мөн энэ баримт бичиг

сүүлийн жилүүдэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр яригдах болсон хээл хахууль, албан тушаалын томоохон гэмт хэрэгт холбогдсон хүмүүсийн асуудлыг хөндөөгүй.

Харин энэ тогтоол нийгмийн хамгааллын хувьд эмзэг бүлэгт хамаарах иргэдийг, тухайлбал, хүүхэдтэй болон 55-аас дээш настай эмэгтэйчүүд, хүмүүжлийн колонид ял эдэлж буй ихэнх хүүхдүүдийг, 60-аас дээш настай эрэгтэйчүүд болон тогтоолд дурьдсан бусад хүмүүсийг эрх чөлөөг амьдралд гаргасан. Энэ байдлууд нь миний үзэл бодолтой нийцэж байна.

Засан хүмүүжүүлэх байгууллагуудаас ойролцоогоор 3 мянга хүн суллагдаж, мөн мөрдөн шалгах шатанд эрүүгийн хэрэг үүсгэгдсэн хэрэг нь хянагдаж буй цөөнгүй хүмүүсий асуудал хэрэгсэхгүй болно.

Данил Корецкий
ОХУ-ын гавъяат
хуульч, хууль зүйн
шинжлэх ухааны
доктор, Холбооны
Өмнөд тойргийн их
сургуулийн Эрүүгийн
эрх зүй,
криминологийн
тэнхимийн
профессор, зохиолч, цагдан сэргийлэхийн
бэлтгэл хурандаа



Хэрвээ өршөөл нь гэмт хэргийг санамсар болггомжгүй эсвэл амьдралын хүнд нөхцлийн улмаас, мөн аргагүй хамгаалалтын хэр хэмжээг хэтрүүлэн үйлдсэн хүмүүсийн ялыг хөнгөрүүлэхэд чиглэгдэж байвал хэрэгтэй. Өөрөөр хэлбэл амьдарлын хэв маяг нь тогтвортойгоор гэмт явдалтай холбогдолгүй хүмүүст өршөөл үйлчлэх ёстой.

Харин эдийн засгийн залилан мэхлэгчид, хүч хэрэглэсэн танхайчуудад хүнлэг энэрэнгүй байдал шууд хамаарахгүй. Оросын колониудад гахай, үр тариа, галуу хулгайлсан тосгоны цөөнгүй иргэд ял эдэлж байна. Гэтэл олон мянга, сая, тэрбум рублийн хохирол учруулсан ашиглан шамшигдлуулгач этгээдүүдэд тэнсэн харгалзах ял оногдуулсан практик нь эцсийн дүндээ хууль, шударга ёс, хүмүүсийг доромжилж буй хэрэг юм.

Үнэхээр эдгээр хүмүүсийн байрыг солих ёстой ба энэхүү өршөөлийн тогтоол ч энэ байдлыг авч үзээгүй байна.

Энэ дашрамд дурдахад уучлалаас өршөөлийн ялгарах гол онцлог нь тодорхой нэр заасан хүмүүст хэрэглэгддэггүй. Тэгвэл батлагдсан өршөөлийн тогтоол энэ зарчмаас хазайж, түүний хэм хэмжээ тодорхой бүлгийн хүмүүсийг түүнд хамруулах, бусдыг нь хамруулахгүй байх бодлогод суурилжээ.

Энэ бол өршөөлийн зарчмуудыг зөрчсөн явдал мөн.



Мария Каннабих

*“Олон нийтийн
хяналтын
комиссуудын
зөвлөл”*

*Бүх оросын
төрийн бус
байгууллагын
Тэргүүлэгчдийн
дарга*

ОХУ-ын Үндсэн хуулийн 20 жилийн ойтой холбогдуулан боловсруулсан Өршөөлийн тогтоолын хувилбарууд зөвхөн Төрийн Думд л гэхэд маш олон байсан. Би ОХУ-ын Нийтийн танхим ба

Ерөнхийлөгчийн дэргэдэх хүний эрхийн асуудлаарх Зөвлөлийн хэмжээнд боловсрогдсон энэ төрлийн баримт бичгийн талаар яриагүй байна.

Өршөөлийн баримт бичгийн хувилбаруудад маргаантай олон зүйлүүд байсан ба эцсийн үр дүнд батлагдсан тогтоол ч бүгдийн хүсэл сониорхолд нийцээгүйг ойлгож байна.

Мэдээж би хоригдлуудад туслах Фондын ерөнхийлөгчийн хувьд өршөөлийн тогтоол өргөн хүрээг хамарч олон ялтнуудад хүрч үйлчлэхийг хүссэн. Гэхдээ өршөөлийн тогтоол батлагдсан нь өөрөө амжилт.

Манай улсын шүүгчид хууль зөрчигчдөд зарим талаар илүү хүнлэг хандаасай гэж хүсдэг. Тухайлбал хахууль авсан эмч, хуульч, багш зэрэг хүмүүсийг хорих ялаар шийтгэх нь илүү хатуудаж байх болох юм. Учир нь тэдэнд электрон гав зүүх юм уу эсвэл гэрийн хорионд байлгах замаар асуудлыг шийдэж болно.

Хамгийн гол нь гэм буруугаа ойлгон ухамсарлах явдал ба энэ нь дахин алдаагаа давтахгүй байх баталгаа болж болно. Илүү хөнгөн арга хэмжээг энэ тохиолдолд авч болно шүү дээ. Хорих газарт эдгээр хүмүүсийг байлгаж улсын хөрөнгийг зарцуулах явдлыг бид илүү зүйл гэж үздэг.

Өршөөл зарлахын зэрэгцээ суллагдсан хүмүүс хаашаа очих, нийгэмд хэрхэн дасан зохицож хэвийн амьдралд цаашдаа шилжих, мөн сургууль, хөдөлмөр эрхлэлттэй холбогдсон асуудлууд нь хэрхэн шийдвэрлэгдэхийг урьдчилан тооцоолж зохих бэлтгэлийг хангахад л төр гол анхаарлаа хандуулах ёстой.

Чухам эдгээр алхамуудыг шийдвэрлээгүйгээс л өршөөлөөр суллагдсан хүмүүс эргэн хорих газар луу ордог шүү дээ.

Албан албан бус хөрвүүлэг

**ОХУ-ЫН ТӨРИЙН ДУМЫН
2013 ОНЫ 12-Р САРЫН 18-НЫ ӨДРИЙН
ТОГТООЛ №3500-6 ГД**

**“ОХУ-ЫН ҮНДСЭН ХУУЛЬ
БАТЛАГДСАНЫ 20 ЖИЛИЙН ОЙТОЙ
ХОЛБОГДУУЛАН ӨРШӨӨЛ ҮЗҮҮЛЭХ
ТУХАЙ”**



Нийтлэгдсэн: 2013 оны 12-р сарын 19-ны өдрийн “Российская Газета”-

Холбооны дугаар № 6262

Хүчин төгөлдөр болсон: 2013 оны 12-р сарын 19-ны өдөр

ОХУ-ын Үндсэн хууль батлагдсаны 20 жилийн ойтой холбогдуулан хүнлэг ёсны зарчмыг удирдлага болгон ОХУ-ын Үндсэн хуулийн 103-р зүйлийн 1 дэх хэсгийн “ж” заалтын хүрээнд ОХУ-ын Холбооны Хурлын Төрийн Думаас тогтоох нь:

1. Ялаас чөлөөлсүгэй.

-1/ 16 нас хүрээгүй байхдаа гэмт хэрэг үйлдэгдсдийг оролцуулан 5 хүртэл жилийн хорих ялтай ялтнуудыг;

-2/ өмнө нь хүмүүжлийн колонд ял эдлэж байгаагүй, 16-18 хүртэл насандаа гэмт

хэрэг үйлдэж 5 хүртэл жилийн хорих ялаар шийтгэгдсэн ялтнуудыг;

-3/ 18 насанд хүрээгүй байхдаа санаатай гэмт хэрэг үйлдэж 5-аас дээш жилийн хорих ялаар шийтгэгдэн оногдуулсан хорих ялын талаас дээш хувийг эдэлсэн ялтнуудыг.

2. Өмнө нь засан хүмүүжүүлэх байгууллагад ял эдэлж байгаагүй 5 хүртэл жилийн хорих ялтай дараах ялтнуудыг ялаас чөлөөлсүгэй:

-1/ насанд хүрээгүй хүүхэдтэй эмэгтэйчүүдийг;

-2/ жирэмсэн эмэгтэйчүүдийг;

-3/ 55-аас дээш настай эмэгтэйчүүдийг;

-4/ 60-аас дээш настай эрэгтэйчүүдийг;

-5/ Чернобылийн атомын цахилгаан станцын ослын үр дагаварыг арилгахад оролцсон хүмүүсийг;

-6/ ОХУ-ын цэргийн албан хаагчид, дотоод хэргийн байгууллагууд, эрүүгийн ял эдлүүлэх системийн ажилтнууд, зэвсэгт ажиллагаа болон эх орноо хамгаалах үйл



ажиллагаанд оролцсон хүмүүсийг;

-7/ Тахир дутуугийн 1, 2 зэрэгтэй хүмүүсийг.

3. ОХУ-ын Эрүүгийн хуулийн 212-р зүйлийн 2, 3 хэсэг⁷⁸, 213-р зүйл⁷⁹, 264-р зүйлийн 1 хэсэг⁸⁰ тусгагдсан гэмт хэргийг үйлдсэн ял эдлэгсдийг ялаас чөлөөлсүгэй.

4. 18 насанд хүрээгүй байхдаа гэмт хэрэг үйлдэж хорих ялтай холбогдолгүй ял эдлэгсэдийг, мөн энэхүү тогтоол хүчин төгөлдөр болж мөрдөгдөх өдрөөс өмнө тэнсэн харгалзах болон хорих ялаас хугацааны өмнө тэнсэн суллагдсан ялтнуудын хувьд ял нь хойшлогдсон эсвэл энэхүү тогтоолыг хүчин төгөлдөр болж мөрдөгдөх өдрийг хүртлэх хугацаанд ялын эдлээгүй хэсэг нь илүү хөнгөн ялаар солигдсон ялтнуудыг тус тус ялаас чөлөөлсүгэй.

5. Энэ тогтоолын 2 заалтын 1-7 дэд заалтуудад дурдагдсан хүмүүсийг, мөн энэхүү тогтоол хүчин төгөлдөр болж мөрдөгдөх өдрөөс өмнө тэнсэн харгалзах болон хорих ялаас хугацааны өмнө тэнсэн суллагдсан ялтнуудын хувьд ял нь хойшлогдсон эсвэл энэхүү тогтоолыг хүчин төгөлдөр болж мөрдөгдөх өдрийг хүртлэх хугацаанд ялын эдлээгүй хэсэг нь илүү хөнгөн ялаар солигдсон ялтнуудыг тус тус ялаас чөлөөлсүгэй.

⁷⁸ Олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал /2 дах хэсэг: энэ үйл ажиллагаанд оролцсон бол. 3 дах хэсэг: олон нийтийн эмх замбараагүй байдлыг, түүнд оролцохыг уриалах болон иргэдэд хүч хэрэглэхийг уриалсан бол

⁷⁹ Танхайрах

⁸⁰ Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих /1 дэх хэсэг: авто тээврийн хэрэгсэл, трамвай болон бусад механик тээврийн хэрэгслийг жолоодож буй этгээд хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн аюулгүй байдлын журам зөрчиж болгоомжгүй байдлаар хүний эрүүл мэндэд хүнд гэмтэл учруулсан бол

6. Энэхүү тогтоол хүчин төгөлдөр болж үйлчлэх өдөр хүртлэх хугацаанд үйлдэгдсэн хэрэг бүртгэлт, урьдчилан мөрдөн шалгах байгууллагууд болон шүүхээр хянан хэлэлцэх шатанд байгаа гэмт хэргийн тухай эрүүгийн хэргүүдийг дараах этгээдүүдийн хувьд зогсоосугай.

-1/ 5-аас дээшгүй жилийн хорих ял оногдуулах гэмт хэргийг 16 насанд хүрээгүй этгээдээс үйлдэн сэжигтнээр, яллагдагчаар татагдсан бол;

-2/ 5-аас дээшгүй жилийн хорих ял оногдуулах гэмт хэргийг 16-18 хүртэлх насандаа үйлдэн сэжигтэн, яллагдагчаар татагдсан бөгөөд өмнө нь хүмүүжлийн колонид ял эдэлж байгаагүй бол;

-3/ Энэхүү тогтоолын 2 заалтын 1-7 дэд заалтуудад дурдагдсан 5-аас дээшгүй жилийн хорих ял оногдуулах гэмт хэрэгт сэжигтэн, яллагдагчаар татагдсан бөгөөд өмнө нь Засан хүмүүжүүлэх байгууллагад ял эдэлж байгаагүй бол;

-4/ 18 насанд хүрээгүй байхдаа гэмт хэрэг үйлдэн сэжигтэн, яллагдагчаар татагдсан, тэрчлэн энэ тогтоолын 2 заалтын 1-7 дэд заалтуудад дурдагдсан хүмүүсээс хэрэв сэжигтэн, яллагдагчаар татагдсан гэмт хэргийнх нь төлөө хорихоос өөх төрлийн ял оногдуулах бол

-5/ ОХУ-ын Эрүүгийн хуулийн 212 зүйлийн 2,3 дах хэсэг, 213 зүйл, 264 зүйлийн 1 хэсэгт тусгагдсан гэмт хэрэг үйлдсэнд сэжиглэгдсэн, яллагдагчаар татагсдыг.

7. Энэ тогтоол хүчин төгөлдөр болж үйлчлэх өдрөөс өмнө 5-аас дээшгүй жилийн хорих ял оногдуулах гэмт хэргийг 16 насанд хүрээгүй этгээд үйлдсэн, мөн өмнө нь хүүхдийн колонд ял эдэлж байгаагүй 16-18

хүртлэх насны хүмүүсээс үйлдсэн гэмт хэргийн төлөө шүүх хэрэв 5 хүртэл жилийн хорих ялыг багтаасан ял оногдуулах шаардлагатай гэж хүлээн зөвшөөрвөл холбогдох хүмүүсийг ялаас чөлөөлсүгэй.

8. Энэхүү тогтоол хүчин төгөлдөр болж үйлчлэх өдрөөс өмнө тогтоолын 2-р заалтын 1-7 дахь дэд заалтад дурдагдсан, өмнө нь засан хүмүүжүүлэх байгууллагад ял эдэлж байгаагүй хүмүүсээс 5-аас дээш жилийн хорих ял оногдуулах гэмт хэрэг үйлдсэн ба хэрэв шүүх 5 хүртэл жилийн хорих ялыг багтаасан ял оногдуулах шаардлагатай гэж хүлээн зөвшөөрвөл холбогдох хүмүүсийг ялаас чөлөөлсүгэй.

9. Энэхүү тогтоол хүчин төгөлдөр болж үйлчлэх өдрөөс өмнө тогтоолын 1 заалтын 1, 2 дахь дэд заалт, 2 заалтын 1-7 дахь дэд заалтад дурдагдсан хүмүүс гэмт хэрэг үйлдсэн ба хэрэв шүүх тэдэнд хорихоос өөр төрлийн ял, тэнсэн харгалзах эсвэл ял эдлэх хугацааг хойшлуулах шаардлагатай гэж хүлээн зөвшөөрвөл тэдгээр хүмүүсийг ялаас чөлөөлсүгэй.

10. Энэ тогтоолын үйлчлэл дараах гэмт хэрэг үйлдсэн ялтнуудад хамаарахгүй

-1/ ОХУ-ын Эрүүгийн хуулийн 105 зүйл⁸¹, 111 зүйл⁸², 117 зүйлийн 2 дахь хэсэг⁸³,

122 зүйлийн 3 дахь хэсэг⁸⁴, 126 зүйл⁸⁵, 127 зүйлийн 3 дахь хэсэг⁸⁶, 127-1 зүйл⁸⁷, 127-2 зүйл⁸⁸, 128 зүйлийн 2 дахь хэсэг⁸⁹, 131 зүйл⁹⁰, 132 зүйл⁹¹, 133 зүйлийн 2 дахь хэсэг⁹², 134 зүйл⁹³, 135 зүйл⁹⁴, 146 зүйл⁹⁵, 147 зүйл⁹⁶, 150 зүйлийн 3, 4 дэх хэсэг⁹⁷, 158 зүйлийн 3, 4 дахь хэсэг⁹⁸, 159 зүйлийн 3, 4 дахь хэсэг⁹⁹, 159-1 зүйлийн 3, 4 дахь хэсэг¹⁰⁰, 159-2 зүйлийн 3,

байгуулалттай бүлгээс үйлдсэн бол. ж. Хөлсөөр үйлдсэн. з. Улс төр, үзэл суртал, арьсны, үндэсний, шашных нь хувьд үзэн ядаж, дайсагнаж, эсхүл нийгмийн бүлгийнх нь хувьд үзэн ядаж, дайсагнаж үйлдсэн бол/

⁸⁴ ДОХ тараах /3 дахь хэсэг: хоёр, түүнээс олон хүний, мөн насанд хүрээгүй хүний харьцаанд үйлдсэн бол//

⁸⁵ Хүн хулгайлах

⁸⁶ Хууль бусаар хорих /3 дахь хэсэг: зохион байгуулалттай бүлгээс үйлдсэн, мөн болгоомжгүй гэм буруугийн хэлбэрээр хохирогчийг үхэлд хүргэсэн эсхүл бусад хүнд үр дагаварыг бий болгосон бол/

⁸⁷ Хүн худалдаалах

⁸⁸ Боолчлох

⁸⁹ Сэтгэцийн эмнэлэгт хууль бусаар байлгах /2 дахь хэсэг: албаны байдлаа ашиглан үйлдсэн, эсхүл болгоомжгүй гэм буруугийн хэлбэрээр хохирогчийг үхэлд хүргэсэн эсхүл бусад хүнд үр дагаварыг бий болгосон бол

⁹⁰ Хүчиндэх

⁹¹ Бэлгэсийн шинжтэй хүчирхийллийн үйлдэл

⁹² Бэлгэсийн шинжтэй үйлдэлд албадаа /2 дахь хэсэг: насанд хүрээгүй хүний харьцаанд үйлдсэн бол/

⁹³ Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй хурцаал үйлдэх болон түүний харьцаанд бэлгэсийн шинжтэй бусад үйлдлийг хийх

⁹⁴ Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах

⁹⁵ Зохиогчийн болон гүүнтэй холбоотой бусад эрхийг зөрчих

⁹⁶ Бүтээн тууривах болон патентын эрхийг зөрчих

⁹⁷ Насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэрэг үйлдэхэд татан оруулах /3 дахь хэсэг: Хүч хэрэглэж эсхүл хэрэглэхээр заналхийлж хийсэн бол. 4 дахь хэсэг: энэ зүйлийн 1, 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэргийг үйлдсэн нь насанд хүрээгүй хүнийг гэмт бүлэгт татан оруулахтай, хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдэхтэй, мөн улс төр, үзэл суртал, арьсны, үндэсний, шашных нь хувьд үзэн ядаж, дайсагнаж, эсхүл нийгмийн бүлгийнх нь хувьд үзэн ядаж, дайсагнаж гэмт хэрэг үйлдэхэд татан оруулсан бол/

⁹⁸ Хулгайлах гэмт хэрэг /3 дахь хэсэг нь: орон байранд хууль бусаар нэвтрэн орж, эсхүл нефть дамжуулах хоолойгоос, нефтийн бүтээгдхүүний хоолойгоос, байгалийн хийн хоолойгоос. 4 дэх хэсэг нь: зохион байгуулалттай бүлгээс, онц их хэмжээтэй/

⁹⁹ Залилан мэхлэх гэмт хэрэг /3 дахь хэсэг: албаны байдлаа ашиглан залилан мэхлэх гэмт хэргийг үйлдсэн болон их хэмжээний хохирол учруулсан. 4 дэх хэсэг энэ гэмт хэргийг зохион байгуулалттай бүлгээс үйлдсэн эсвэл онц их хэмжээтэй хохирол учруулсан болон иргэний орон сууц эзэмших эрхийг хассан хохирол учруулсан/

¹⁰⁰ Зээлийн салбар дахь залилан мэхлэх гэмт хэрэг /3 дахь хэсэг: албаны байдлаа ашиглан залилан мэхлэх гэмт

⁸¹ Бусдыг алах

⁸² Бусдын эрүүл мэндэд хүнд хор уршиг санаатайгаар учруулах

⁸³ Бусдыг тарчлаах /2 дахь хэсэг: Энэ гэмт хэргийг а. Хоёр, түүнээс олон хүний харьцаанд үйлдсэн бол. б. албаны үүргээ хэрэгжүүлж буй болон нийтийн үүргээ гүйцэтгэсэнтэй нь холбогдуулан тухайн этгээд болон ойр доны хүмүүсийн харьцаанд үйлдсэн бол. в. Гэмт хэрэг үйлдэгчийн хувьд илт жирэмсэн эмэгтэй харьцаанд үйлдсэн бол. г. Гэмт хэрэг үйлдэгчийн хувьд илт насанд хүрээгүй, илт биеэ хамгаалах чадваргүй эсхүл гэмт хэрэгтнээс материаллаг болон бусад байдлаар хамааралтай, түүнчлэн хулгайлагдсан, барьцаанд авсан хүний харьцаанд үйлдсэн бол. д.эрүүдэн шүүлт хэрэглэж, е.бүлэг этгээд, эсхүл урьдчилан тохиролцсоны дагуу бүлэг этгээд, мөн зохион

4 дах хэсэг¹⁰¹, 159-3 зүйлийн 3, 4 дах хэсэг¹⁰², 159-4 зүйлийн 3 дах хэсэг¹⁰³, 159-5 зүйлийн 3, 4 дах хэсэг¹⁰⁴, 159-6 зүйлийн 3, 4 дэх хэсэг¹⁰⁵, 160 зүйлийн 3, 4 дах хэсэг¹⁰⁶, 161 зүйлийн 2, 3 дах хэсэг¹⁰⁷, 162 зүйл¹⁰⁸, 163 зүйлийн 2, 3 дах хэсэг¹⁰⁹, 164 зүйл¹¹⁰, 166 зүйлийн 3, 4 дах хэсэг¹¹¹, 169¹¹²,

хэргийг үйлдсэн болон их хэмжээний хохирол учруулсан. 4 дэх хэсэг энэ гэмт хэргийг зохион байгуулалттай бүлгээс үйлдсэн эсвэл онц их хэмжээтэй хохирол учруулсан/

¹⁰¹ Төлбөр хүлээн авах явц дах залилан мэхлэх гэмт хэрэг /3 дах хэсэг: албаны байдлаа ашиглан залилан мэхлэх гэмт хэргийг үйлдсэн болон их хэмжээний хохирол учруулсан. 4 дэх хэсэг энэ гэмт хэргийг зохион байгуулалттай бүлгээс үйлдсэн эсвэл онц их хэмжээтэй хохирол учруулсан/

¹⁰² Төлбөрийн карт ашиглан залилан мэхлэх гэмт хэрэг /3 дах хэсэг: албаны байдлаа ашиглан залилан мэхлэх гэмт хэргийг үйлдсэн болон их хэмжээний хохирол учруулсан. 4 дэх хэсэг энэ гэмт хэргийг зохион байгуулалттай бүлгээс үйлдсэн эсвэл онц их хэмжээтэй хохирол учруулсан/

¹⁰³ Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх салбар дах залилан мэхлэх гэмт хэрэг үйлдэн онц их хэмжээтэй хохирол учруулсан

¹⁰⁴ Даатгалын салбар дах залилан мэхлэх гэмт хэрэг /3 дах хэсэг: албаны байдлаа ашиглан залилан мэхлэх гэмт хэргийг үйлдсэн болон их хэмжээний хохирол учруулсан. 4 дэх хэсэг энэ гэмт хэргийг зохион байгуулалттай бүлгээс үйлдсэн эсвэл онц их хэмжээтэй хохирол учруулсан/

¹⁰⁵ Цахим хэрэгсэлийн мэдээллийн салбар дах залилан мэхлэх гэмт хэрэг /3 дах хэсэг: албаны байдлаа ашиглан залилан мэхлэх гэмт хэргийг үйлдсэн болон их хэмжээний хохирол учруулсан. 4 дэх хэсэг энэ гэмт хэргийг зохион байгуулалттай бүлгээс үйлдсэн эсвэл онц их хэмжээтэй хохирол учруулсан/

¹⁰⁶ Бусдын эд хөрөнгийг завших үрэгдүүлэх гэмт хэрэг /3 дах хэсэг: албаны байдлаа ашиглан энэ гэмт хэргийг үйлдсэн болон их хэмжээний хохирол учруулсан. 4 дэх хэсэг энэ гэмт хэргийг зохион байгуулалттай бүлгээс үйлдсэн эсвэл онц их хэмжээтэй хохирол учруулсан/

¹⁰⁷ Булаах гэмт хэрэг /2 дах хэсэг: а. Урьдчилан тохиролцсон бүлэг этгээд в. Орон сууц, байр, бусад байгууламжид хууль бусаар нэвтрэн орж г. Амь нас, эрүүл мэнд аюултай бус байдлаар хүч хэрэглэж эсвэл хүч хэрэглэхээр заналхийлэн үйлдсэн бол. 3 дах хэсэг: Булаах гэмт хэргийг а. Зохион байгуулалттай бүлгээс үйлдсэн. б. Онц их хэмжээтэй хохирол учруулсан бол/

¹⁰⁸ Дээрэмдэх гэмт хэрэг

¹⁰⁹ Бусдын эд хөрөнгийг авахаар далайлган сүрдүүлэх /2 дах хэсэг: а. Урьдчилан тохиролцсон бүлэг этгээд в. Хүч хэрэглэж г. Их хэмжээний хохирол учирсан бол. 3 дах хэсэг: а. Зохион байгуулалттай бүлгээс үйлдсэн. б. Онц их хэмжээний эд хөрөнгийн авах зорилгоор үйлдсэн. в. Хохирогчийн эрүүл мэндэд хүндэвтэр гэмтэл учруулж үйлдсэн

¹¹⁰ Онцгой үнэ цэнэтэй зүйлсийг хулгайлах

¹¹¹ Хулгайлах зорилгогүйгээр авто машин эсхүл тээврийн бусад хэрэгслийг хууль бусаар эзэмших /3 дах хэсэг: энэ

170¹¹³, 170-1¹¹⁴, 171¹¹⁵, 171-1¹¹⁶, 171-2¹¹⁷, 172¹¹⁸, 173-1¹¹⁹, 173-2¹²⁰, 174¹²¹, 174-1¹²², 175¹²³, 176¹²⁴, 177¹²⁵, 178¹²⁶, 179¹²⁷, 180¹²⁸, 181¹²⁹, 183¹³⁰, 184¹³¹, 185¹³², 185-1¹³³, 185-2¹³⁴, 185-3¹³⁵, 185-4¹³⁶, 185-5¹³⁷, 185-6¹³⁸,

гэмт хэргийг зохион байгуулалттай бүлгээс үйлдсэн эсхүл онц их хэмжээний хохирол учруулсан. 4 дэх хэсэг: энэ гэмт хэргийг амь нас, эрүүл мэндэд аюултай байдлаар хүч хэрэглэж эсвэл тийм хүч хэрэглэхээр заналхийлэн үйлдсэн бол/

¹¹² Хууль ёсны аж ахуй эрхлэх болон бусад үйл ажиллагаанд саад тогтогч учруулах

¹¹³ Газартай холбогдсон хууль бус хэлшийг бүртгэх

¹¹⁴ Хуулийн этгээдийн улсын нэгдсэн бүртгэл, үнэт цаас эсхүл архивын тоо баримтын бүртгэлийг хуурамчаар үйлдэх

¹¹⁵ Хууль бусаар аж ахуй эрхлэх

¹¹⁶ Шошгогүй бүтээгдэхүүн, хүнсний зүйлсийг үйлдвэрлэх, олж эзэмших, хадгалах, тээвэрлэх эсвэл худалдаалах

¹¹⁷ Мөрийтэй тоглоомыг хууль бусаар зохион байгуулах, явуулах

¹¹⁸ Хууль бус банкны үйл ажиллагаа

¹¹⁹ Хуулийн этгээдийг хууль бусаар бий болгох /үүсгэх, өөрчлөн зохион байгуулах/

¹²⁰ Хуулийн этгээдийг байгуулахын тулд баримт бичгийг хууль бусаар ашиглах

¹²¹ Мөнгө угаах /гэмт хэргийн улмаас бусад хүмүүс олж авсан мөнгө, эд зүйлсийг хууль ёсны болгох/

¹²² Гэмт хэрэг үйлдсэний үр дүнд олж авсан мөнгө бусад эд хөрөнгийг /угаах/ хууль ёсны болгох

¹²³ Илт гэмт хэргийн замаар олж авсан эд зүйлсийг эзэмших, борлуулах

¹²⁴ Эзэллэг хууль бусаар авах

¹²⁵ Эзэлийн өр төлбөрөө барагдуулахаас санаатайгаар зайлсхийх

¹²⁶ Өрсөлдөөнийг гаргуулахгүй байх, хязгаарлах, эсхүл үгүй болгох

¹²⁷ Хэлцэл хийлгэхээр эсхүл түүнийг хийлгэхээс татгалзуулах зорилгоор албадах

¹²⁸ Барааны тэмдэгтийг хууль бусаар ашиглах

¹²⁹ Улсын татварын тэмдэг бүхий шошгыг бэлтгэх, ашиглах журмыг зорчих

¹³⁰ Худалдаа, татвар болон банкны нууц бүхий мэдээллийг хууль бусаар олж авах, задруулах

¹³¹ Мэргэжлийн спортын тэмцээн, олон нийтийн дунд зохион байгуулах ашиг олох уралдааны оролцогч, зохион байгуулагчийг худалдан авах

¹³² Банкнаас үнэт цаасыг гаргах ажилд зүй бусаар хандах

¹³³ Үнэт цаасны тухай ОХУ-ын хууль тогтоомжоор тодорхойлогдсон мэдээллийг ил болгох эсхүл олгохоос санаатайгаар зайлсхийх

¹³⁴ Үнэт цаасны эрхийн тоо бүртгэлийн журам зөрчих

¹³⁵ Зах зээлийг төөрөгдөлд оруулах

¹³⁶ Эзэмшигчээс үнэт цаасны эрхээ хэрэгжүүлэхэд нь саад болох эсвэл эрхийг нь хууль бусаар хязгаарлах

¹³⁷ Аж ахуйн нийгэмлэгийн хувь нийлүүлэгчдийн нийтийн хурал эсвэл захирлуудын зөвлөлийн шийдвэрийг хуурамчаар үйлдэх

¹³⁸ Инсайдерын мэдээллийг хууль бусаар ашиглах

186¹³⁹, 187¹⁴⁰, 189¹⁴¹, 190¹⁴², 191¹⁴³, 192¹⁴⁴,
193¹⁴⁵, 193-1¹⁴⁶, 194¹⁴⁷, 195¹⁴⁸, 196¹⁴⁹, 197¹⁵⁰,
198¹⁵¹, 199¹⁵², 199-1¹⁵³, 199-2¹⁵⁴, 200-1¹⁵⁵,
205¹⁵⁶, 205-1¹⁵⁷, 205-2¹⁵⁸, 205-3¹⁵⁹, 205-4¹⁶⁰,
205-5¹⁶¹, 206¹⁶², 208¹⁶³, 209¹⁶⁴, 210¹⁶⁵, 211¹⁶⁶,

¹³⁹ Хуурамч мөнгөн тэмдэгт, үнэт цаасыг бэлтгэх, хадгалах, тээвэрлэх, борлуулах

¹⁴⁰ Хуурамч зээлийн болон тооцооны карт, бусад төлбөрийн баримт бичгийг бэлтгэх, борлуулах

¹⁴¹ Түүхий эд, эд материал, тоног төхөөрөмж, технологи, шинжлэх ухаан техникийн мэдээллийг ОХУ-аас хууль бусаар экспортлох, үй олноор хөнөөх зэвсэг, байлдааны хэрэгсэл, цэргийн техникийг бүтээхэд ашиглах боломжтой ажил үйлчилгээг хууль бусаар гүйцэтгэх

¹⁴² ОХУ-ын ард түмний болон гадаадын орнуудын урлаг, уран сайхан, түүхийн, археологийн үнэт олдворт хамаарах зүйлсийг ОХУ-ын нутаг дэвсгэрт эргүүлэн үл авчрах

¹⁴³ Үнэт металл, байгалийн үнэт чулуу, эд зүйлсийн хууль бус эргэлт

¹⁴⁴ Үнэт металл, үнэт чулууг улсад өгөх журмыг зөрчих

¹⁴⁵ Гадаад улсад байгаа их хэмжээний валютаар үнэлэгдэх эд зүйлсийг эргүүлэн авчрахгүй байх

¹⁴⁶ Гадаад улсын валют эсвэл ОХУ-ын валютаар байгаа мөнгөн хөрөнгийг хуурамч бичиг баримт ашиглан бусдын дансанд шилжүүлэх валютын ажиллагааг хийх

¹⁴⁷ Төлөх ёстой гаалийн татвараас байгууллага, хувь этгээдүүд зайлсхийх

¹⁴⁸ Дампуурлын явц дахь хууль бус үйл ажиллагаанууд

¹⁴⁹ Санаатайгаар төлбөрийн чадваргүй болгох, дампууруулах

¹⁵⁰ Дампуурсан тухай илт худал мэдээллийг нийтэд цацах

¹⁵¹ Хувь хүмүүсээс төлбөл зохих татвар, хураамжаа зайлсхийх

¹⁵² Албан байгууллагуудаас төлбөл зохих татвар, хураамжаас зайлсхийх

¹⁵³ Татварын байгууллагаас үүргээ үл биелүүлэх

¹⁵⁴ Байгууллага, хувинараа хөдөлмөр эрхлэгчдийн татвар, хураамжид ноогдох ёстой мөнгөн хөрөнгө, эд зүйлсийг нуун даллах

¹⁵⁵ Бэлэн мөнгөн хөрөнгө болон мөнгөн хэрэгслийг хууль бусаар хил гаргах

¹⁵⁶ Террорист акт

¹⁵⁷ Террорист үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх

¹⁵⁸ Террорист үйл ажиллагаа явуулахад бүх нийтийг уриалах болон терроризмыг илтгээр зөвтгөх

¹⁵⁹ Террорист үйл ажиллагаа явуулах зорилгоор сургалтанд хамрагдах

¹⁶⁰ Террорист нийгэмлэгийг зохион байгуулах, түүнд оролцох

¹⁶¹ Террорист байгууллагын үйл ажиллагааг зохион байгуулах, тийм байгууллагын үйл ажиллагаанд оролцох

¹⁶² Барьцаанд авах

¹⁶³ Хууль бус зэвсэгт бүлэглэлийг байгуулах ба түүнд оролцох

¹⁶⁴ Зандалчлах

¹⁶⁵ Гэмт нийгэмлэгийг /гэмт хэргийн байгууллагыг/ зохион байгуулах болон түүний үйл ажиллагаанд оролцох

¹⁶⁶ Агаарын хөлөг, усан тээврийн хэрэгсэл, төмөр замын хөдөлдөг бүрэлдэхүүнийг авч зугтаах

212 зүйлийн 1 дах хэсэг¹⁶⁷, 215-2 зүйлийн 3 дах хэсэг¹⁶⁸, 215-3 зүйлийн 3 хэсэг¹⁶⁹, 221 зүйл¹⁷⁰, 222 зүйл¹⁷¹, 223 зүйлийн 1, 2, 3 дах хэсэг¹⁷², 226¹⁷³, 226-1¹⁷⁴, 227¹⁷⁵, 228¹⁷⁶, 228-1¹⁷⁷, 228-2¹⁷⁸, 228-3¹⁷⁹, 228-4¹⁸⁰, 229¹⁸¹, 229-

¹⁶⁷ Нийтийн эмх замбараагүй байдал /1-р хэсэг Нийтийн эмх замбараагүй байдлыг зохион байгуулсаны дүнд хүчирхийлэл, эд хөрөнгийг эвдэн сүйтгэх, галдан шатаах, устгах ажиллагаа явагдсан, түүнчлэн галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис хэрэгсэл ашиглан явагдсан болон засгийн төлөөлөгчдөд зэвсэгт эсэргүүцэл үзүүлсэн/

¹⁶⁸ Шаардлага хангахуйц объектыг ашиглах боломжгүй болгоход хүргэх

¹⁶⁹ Нефт дамжуулах хоолой, нефтийн бүтээгдэхүүн, байгалийн хийг дамжуулах хоолойг ажиллагаагүй болгох /3-р хэсэг Энэ гэмт хэргийг үйлдсэний улмаас болгоомжгүй байдлаар хүн нас барсан эсвэл бусад хүнд хор уршиг учирсан бол/

¹⁷⁰ Цөмний металл, радио цацраг бүхий зүйлсийг хулгайлах, заналхийлж авах

¹⁷¹ Зэвсэг, түүний бүрэлдэхүүн хэсэг сум хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх эд зүйлс, бодисыг хууль бусаар олж авах, дамжуулах, борлуулах, хадгалах, тээвэрлэх, биедээ авч явах

¹⁷² Зэвсгийг хууль бусаар бэлтгэх /1 дах хэсэг: Галт зэвсэг түүний эд зүйлсийг хууль бусаар бэлтгэх, дуурайлган хийх эсвэл засварлах, 2 дах хэсэг: Энэ гэмт хэргийг урьдчилан тохиролцсон дагуу бүлэглэн үйлдсэн, 3 дах хэсэг: Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай бүлгээс үйлдсэн/

¹⁷³ Зэвсэг, сум хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх эд зүйл хэрэгслийг хулгайлах, заналхийлж авах

¹⁷⁴ Хүчтэй нөлөөлөх, хортой, хордуулах, дэлбэрэх, радио цацраг бүхий эд зүйлс, радио цацрагийн эх үүсвэрүүд, цөмийн материал, галт зэвсэг, түүний эд анги, тэсрэх хэрэгсэл, сум, үй олноор хөнөөх зэвсэг, түүнийг хүргэх хэрэгсэл бусад байлдааны зэвсэг, техникийг хууль бусаар хил дамжуулан худалдаалах

¹⁷⁵ Далайн дээрэм

¹⁷⁶ Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодис, тэдгээртэй адилтгах зүйлсийг хууль бусаар олж авах, хадгалах, тээвэрлэх, бэлтгэх, дахин боловсруулах болон мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх зүйлсийг агуулсан ургамал, түүний хэсгийг хууль бусаар олж авах, хадгалах, тээвэрлэх

¹⁷⁷ Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодис, тэдгээртэй адилтгах зүйлсийг хууль бусаар үйлдвэрлэх, борлуулах, дамжуулан илгээх болон мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх зүйлсийг агуулсан ургамал, түүний хэсгийг хууль бусаар үйлдвэрлэх, борлуулах, дамжуулах

¹⁷⁸ Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисын эргэлтийн журмыг зөрчих

¹⁷⁹ Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар олж авах, хадгалах, тээвэрлэх болон мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх зүйлсийг агуулсан ургамал, түүний хэсгийг хууль бусаар олж авах, хадгалах, илгээх

¹⁸⁰ Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар үйлдвэрлэх, борлуулах, дамжуулах болон мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх зүйлсийг агуулсан

1¹⁸², 230¹⁸³, 231¹⁸⁴, 232¹⁸⁵, 234¹⁸⁶, 240¹⁸⁷,
241¹⁸⁸, 242-1¹⁸⁹, 242-2¹⁹⁰, 264 зүйлийн 2, 3, 4,
5, 6 хэсэг¹⁹¹, 275¹⁹², 276¹⁹³, 277¹⁹⁴, 278¹⁹⁵,
279¹⁹⁶, 281¹⁹⁷, 282¹⁹⁸, 282-1¹⁹⁹, 282-2²⁰⁰, 286
зүйлийн 3 дах хэсэг²⁰¹, 290²⁰², 291²⁰³, 291-

ургамал, түүний хэсгийг хууль бусаар борлуулах, хадгалах, илгээх

¹⁸¹ Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодис болон түүнийг агуулж буй ургамал, түүний хэсгийг хулгайлах, заналхийлэн авах

¹⁸² Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодис, тэдгээрийг агуулж буй ургамал, түүний хэсгийг хууль бусаар хил гаргах

¹⁸³ Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодис, тэдгээртэй адилтгах зүйлсийг хэрэглэхэд турхирах

¹⁸⁴ Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг агуулсан ургамлыг хууль бусаар тариалах

¹⁸⁵ Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодис, тэдгээртэй адилтгах зүйлсийг хэрэглэх газрыг бий болгон зохион байгуулах, агуулах

¹⁸⁶ Хүчтэй үйлчлэх болон хорт бодисыг борлуулах зорилгоор хууль бусаар эргэлтэд оруулах

¹⁸⁷ Биеэ үнэлэх үйл ажиллагаанд татан оруулах

¹⁸⁸ Биеэ үнэлэх явдлыг зохион байгуулах

¹⁸⁹ Садар самууныг сурталчилсан материал, эд зүйлсийг хууль бусаар бэлтгэх, эргэлтэд оруулах

¹⁹⁰ Садар самуун бүхий материал эд зүйлсийг бэлтгэх зорилгоор насанд хүрээгүй хүмүүсийг ашиглах

¹⁹¹ Замын хөдөлгөөн, тээврийн хэрэгслийн ашиглалтын дүрмийн зөрчил /2 дахь хэсэг: Энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан гэмт хэргийг согтуугаар үйлдэж болгоомжгүйгээр хүний эрүүл мэндэд хүнд гэмтэл учруулах. 3 дахь хэсэг: Энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсан гэмт хэргийг үйлдэж хүний амь насыг болгоомжгүйгээр хохироосон. 4 дэх хэсэг: дурдсан гэмт хэргийг согтуугаар үйлдсэний улмаас болгоомжгүйгээр хүний амь нас хохироосон. 5 дахь хэсэг: Дурдсан гэмт хэргийг үйлдсэний улмаас 2 ба түүнээс олон хүний амь насыг болгоомжгүйгээр хохироосон бол. 6 дахь хэсэг: Дурдсан гэмт хэргийг согтуугаар үйлдсэний улмаас 2 ба түүнээс олон хүний амь насыг болгоомжгүйгээр хохироосон бол /

¹⁹² Эх орноосоо урвах

¹⁹³ Тагнуул хийх

¹⁹⁴ Төр, нийгмийн зүтгэлтний амь биед халдах

¹⁹⁵ Төрийн эрх мэдлийг хүчээр авах, хүчээр тогтоон барих

¹⁹⁶ Зэвсэглэсэн үймээн дэгдээх

¹⁹⁷ Хорлон сүйтгэх

¹⁹⁸ Үзэн ядалт, дайсагналлыг өлөөх, хүний эрхэмсэг оршихуйг гутаах

¹⁹⁹ Экстремист нийгэмлэгийг зохион байгуулах

²⁰⁰ Экстремист байгууллагын үйл ажиллагааг зохион байгуулах

²⁰¹ Албан тушаалын эрх мэдлээ хэтрүүлэх /3 дахь хэсэг: а/ Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг хүч хэрэглэн эсвэл хүч хэрэглэхээр заналхийлэн үйлдсэн бол. б/ Зэвсэг болон тусгай хэрэгсэл хэрэглэн үйлдсэн бол. в/ хүнд хор уршиг учруулсан бол/

²⁰² Хээл хахууль авах

²⁰³ Хахууль өгөх

1²⁰⁴, 295²⁰⁵, 296²⁰⁶, 299²⁰⁷, 300²⁰⁸, 301 зүйлийн
2, 3 дах хэсэг²⁰⁹, 305 зүйлийн 2 дах хэсэг²¹⁰,
306 зүйлийн 3 дах хэсэг²¹¹, 309 зүйлийн 4
дах хэсэг²¹², 313²¹³, 317²¹⁴, 318²¹⁵, 321²¹⁶, 322-
1²¹⁷, 329²¹⁸, 333²¹⁹, 335²²⁰, 353²²¹, 354²²²,
355²²³, 356²²⁴, 357²²⁵, 358²²⁶, 359²²⁷, 360
зүйл²²⁸,

-2/ Санаатай гэмт хэргийн учир 2-оос
дээш удаа хорих ял эдэлж буй, тэрчлэн

²⁰⁴ Хээл хахууль өгөхөд зуучлах

²⁰⁵ Шүүн таслах ажиллагаа, урьдчилан мөрдөн байцаалтыг хэрэгжүүлэгч этгээдийн амь биед халдах

²⁰⁶ Шүүн таслах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, урьдчилсан мөрдөн байцаалтыг явуулахтай нь холбогдуулан заналхийлэх, хүч хэрэглэх

²⁰⁷ Илт гэм буруугүй хүнийг эрүүгийн хариуцлагад татах

²⁰⁸ Эрүүгийн хариуцлагаас хууль бусаар чөлөөлөх

²⁰⁹ Хууль бусаар саатуулах, цагдан хорих, байривчлах /2 дахь хэсэг: Илт хууль бусаар цагдан хорих, баривчлах. 3 дахь хэсэг: Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт дурдсан гэмт хэргийг үйлдсэний улмаас хүнд хор уршиг учруулсан бол/

²¹⁰ Илт хууль бус шүүхийн тогтоол, шийдвэр, бусад актыг гаргах /2 дахь хэсэг: хорих ялаар ялласан шүүхийн хууль бус тогтоол гарах эсвэл бусад хүнд үр дагаврыг бий болгосон бол/

²¹¹ Зориуд худал мэдээлэл өгөх /3 дахь хэсэг: Гэмт хэрэг үйлдсэн тухай зориуд худал мэдээлэл өгөхдөө яллах нотлох баримтыг зохиомлоор бий болгосон бол/

²¹² Мэдүүлэг өгүүлэхээр, мэдүүлэг өгөхөөс зайлсхийлгэх эсвэл хуурамч орчуулга хийлгэхээр худалдан авах, албадах /4 дэх хэсэг: Зохион байгуулалттай бүлэг үйлдсэн эсвэл дурдсан хүмүүсийн амь бие, эрүүл мэндэд аюултай хүч хэрэглэж үйлдсэн бол/

²¹³ Хорих, баривчлах, цагдан хорихоос оргох

²¹⁴ Хууль сахиулах байгууллагын ажилтны амь биед халдах

²¹⁵ Төр засгийн төлөөлөгчид хүч хэрэглэх

²¹⁶ Нийгмээс тусгаарлах ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааг бусниулах

²¹⁷ Хууль бус шилжилт хөдөлгөөнийг зохион байгуулах

²¹⁸ ОХУ-ын төрийн сүлд, ОХУ-ын төрийн далбааг гутаан доромжлох

²¹⁹ Даргыгаа эсэргүүцэх болон түүнийг цэргийн албаны үүргээ зөрчихөд албадах

²²⁰ Бие биедээ шууд захирагдаагүй цэргийн албан хаагчдаас өөр хоорондын харилцааны дүрмийн заалтыг зөрчих

²²¹ Түрэмгий дайныг төлөвлөх, бэлтгэх, өлөөх, явуулах

²²² Түрэмгий дайн дэгдээхийг нийтэд уриалах

²²³ Үй олноор хөнөөх зэвсгийг бий болгон бүтээх, үйлдвэрлэх, цуглуулах, олж авах, борлуулах

²²⁴ Дайн явуулах хориглоосон хэрэгсэл, аргыг хэрэглэх

²²⁵ Төрлөөр устгах /геноцид/

²²⁶ Байгалийн тэнцэл алдагдуулах /экоцид/

²²⁷ Хөлсний цэрэг ашиглах

²²⁸ Олон улсын хамгаалалтад байдаг хүмүүст халдан довтлох

энэхүү заалтын 1-р дэд заалтад тусгагдсан гэмт хэргийн учир өмнө нь хорих ялаар шийтгэгдэж байсан санаатай гэмт хэрэг үйлдэгч-ялтнууд;

-3/ ЗСБНХОУ-ын Эрүүгийн хуулийн хүрээнд онц аюултай рецидив гэмт хэрэгтнээр тооцогдсон эсхүл ОХУ-ын Эрүүгийн хуулийн хүрээнд онц аюултай рецидив гэмт хэрэгтнээс гэмт хэрэг үйлдсэн бол;

-4/ 1993 оноос хойш уучлалын журмаар, мөн өршөөлийн актын дагуу суллагдсан этгээд дахин санаатай гэмт хэрэг үйлдсэн бол;

-5/ Хорих байгууллагад ял эдэлж байх хугацаандаа дахин санаатай гэмт хэрэг үйлдэгсэд.

11. Энэ тогтоолын үйлчлэл ял эдлэх тогтоосон журмыг ноцтой зөрчигч ялтнуудад хамаарахгүй

12. Энэ тогтоол түүнийг албан ёсоор нийтэлсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох ба 6 сарын хугацаанд түүний гүйцэтгэлийг хангана.

**ОХУ-ын Холбооны Хурлын Төрийн
Думын дарга С.Нарышкин**

ХАГАН ДАХЬ ХААЛТТАЙ ХОРИХ АНГИЙН ДОТООД ЖУРАМ

Өдрийн цагний хуваарь

Өдрийн цаг хугацааг ажлын, амралтын, чөлөөт цаг гэсэн 3 хэсэгт хувааж үзнэ.

Ажлын өдрүүдэд		Бямба гараг
Сэрээх	05.30 цаг	07.15 цаг
Өглөөний цай /давхар цоожийг онгойлох/	06.00 цаг	07.30 цаг
Салхинд гаргах /чанга яригчаар зарлах болно/	07.15 цаг	08.15 цаг
Өдрийн хоол	12.00 цаг	13.00 цаг
5 дахь өдөр өдрийн хоол	13.00 цаг	
Салхинд гаргах /чанга яригчаар зарлах болно/	17.00 цаг	17.00 цаг
Оройн хоол	22.00 цаг	22.00 цаг

Ням гараг болон баярын өдрүүдэд	
Сэрээх	06.15 цаг
Өглөөний цай	06.30 цаг
Салхинд гаргах /чанга яригчаар зарлах болно/	07.10 цаг
Өдрийн хоол	13.00 цаг
Салхинд гаргах /чанга яригчаар зарлах болно/	17.00 цаг
Оройн хоол	22.00 цаг

Ажлын цаг

Дараах ажлын цагт ажиллана.
Хоригдол ажлын цехэд ажиллах цагийн хуваарь:

1 дэх өдрөөс 4 дэх өдөр хүртэл 06.50-11.55 цаг, үдээс хойш 12.50-15.20 цаг

Баасан гарагт
06.50-13.05 цаг

Сайн дураар болон туслах ажилд цалингүй ажиллаж байгаа бол цагийн хуваарь харгалзахгүй ажиллана. Ажил хийж байгаа хоригдлууд ажлын дараа салхинд гарах ёстой.

Салхинд гаргах:

Цаг агаарын тааламжтай үед өдөр бүр 1 цаг салхинд гарна. Хэрэв та гарах хүсэлгүй бол өрөөндөө байж болно. Гэхдээ салхинд гаргахдаа өөр хоригдлуудтай нийлж бүлэг байгуулахыг хориглоно. Мөн эд зүйлсийг бусдад өгөх, авахыг хориглоно. Та тамхи татахгүй байх хэрэгтэй

Амралтын цаг

Амралтын цаг нь танд зориулагдсан учраас бусад хоригдолд саад болохгүйгээр телевизор үзэх, хөгжим сонсож болно. Харин ямар нэгэн хэмжээгээр бусдад саад болохгүй байх ёстой.

Эмчийн үйлчилгээ

Өглөө бүр тасгийн ажилтан таны өрөөг онгойлгох үед та хорих ангийн эмч болон шүдний эмч, сувилагчид очиж үзүүлэх шаардлагатай бол өргөдлөө урьдчилан өгч мэдэгдсэн байх шаардлагатай. Түргэн тусламжийн болон

гэмтлийн зайлшгүй шаардлагатай тохиолдолд дээрх заалт хамаарахгүй.

Эмчийн үзлэгийн цаг

Даваа гарагт II, III, V тасаг

Пүрэв гарагт I, IV, VI, тасгууд хамрагдах болно.

Шүдний эмчийн үзлэг нь Лхагва гарагт явагдана, гэхдээ чанга яригчаар зарлах болно.

Хоригдол нь эрүүл мэндээ хамгаалах болон ариун цэврийг хангах зайлшгүй арга хэмжээнүүдийг дэмжих ёстой.

Усанд орох болон хувцсаа солих

7 хоног 2 удаа усанд орно. Энэ үед өмсөж байгаа хувцсаа солино. Унтлагын хувцсаа 7 хоног бүр солино. Ор хөнжлийн даавууг 14 хоногт 1 удаа солих ба спортын үйл ажиллагааны дараа усанд орох боломжтой.

Эргэлтийн цаг

Өргөдлийн дагуу зөвшөөрсөн хугацаанд эргэлт нь явагдана. Үүнийг дагаж мөрдөөгүй тохиолдолд дараагийн эргэлт хийгдэхгүй болно. Эргэлтээр ирсэн хүний тоо нь хүүхэд оролцуулаад 3 байх ёстой. Эргэлтийн үед зөвшөөрөгдөөгүй зүйлийг өгч, авахыг хориглоно. Харуул хамгаалалтын албаны хяналтын дор хорих ангид байгаа автомат машинаас тамхи болон чихэрлэг бүтээгдэхүүн авч болно.

Эргэлтийн цагийн хуваарь:

Урьдчилан хорих хэсэгт байгаа хүмүүст

Мягмар гарагт 08.15-15.40

Пүрэв гарагт 08.15-15.40

Тухайн хоригдлын гэр бүлийн гишүүд нь ажил хийдэг тохиолдолд

Даваа гарагт 17.45-18.45 болон 18.20-19.20 хооронд эргэлтийг авна.

Эргэлтийн хүсэлтийг өгөгдсөн маягтын дагуу гаргана. Үүний дараа тасгийн даргаас бичгээр эргэлтийн цагийн хугацаа авах ёстой. Эргэлтийн цагийг өөрчлөх болсон тохиолдолд эргэлтийн тасгийн ажилтанд хэлнэ үү.

Таны ар гэрийнхэн энэ олгосон эргэлтийн цагийг холбогдох шүүгч болон прокурорт уламжлан зөвшөөрлийг авна. Тухайн зөвшөөрлийг авч эргэлт явагдах ёстой. Эргэлтийн цаг 14 хоногт нэг удаа 30 минутын хугацаатай байна. Авчирсан хувцас ялангуяа гадуур хувцасыг шууд солилцоно.

Дамжин онгөрүүлэхэд болон хорих ангид байгаа хоригдлуудын эргэлтийн хуваарь

Эргэлтийн хүсэлтийг өгөгдсөн маягтын дагуу тасгийн ажилтанд бөгөлж өгнө, мөн цаг хугацаа нь өөрчлөгдсөн тохиолдолд мэдэгдэнэ. Эргэлтийн үргэлжлэх хугацаа 1 цаг байна.

Даваа гараг	12.45 - 19.40 цаг
Мягмар гараг	12.45 - 15.15 цаг
Лхагва гараг	08.00 - 15.15 цаг
Пүрэв гараг	12.45 - 15.15 цаг
Баасан гараг	08.00 - 11.00 цаг

Худалдаа

Танд хорих байгууллагаас сард 2 удаа хүнсний болон өргөн хэрэглээний бараа худалдан авах боломж олгож байна.

Худалдааны хуваарийг ханын самбараас харж болно. Ямар эд зүйлс хорих байгууллагаар дамжуулан худалдан авч болохыг тасгийн ажилтнаас асууна уу.

Тамхи татах

Хоригдлын өрөөнд тамхи татахыг зөвшөөрнө. Дараах тохиолдолд тамхи татахыг хориглоно:

- Ажлын цехэд зөвшөөрөгдөөгүй тохиолдолд
- Хорих байранд татах өрөөнөөс бусад газар
- Сүмийн зориулалтай өрөөнүүдэд
- Спортын үйл ажиллагаа явуулж байгаа өрөөнүүдэд
- Тамхи татахыг хориглосон тэмдэгтэй газар өөрөөр хэлбэл ажилтан тамхи татахыг хориглосон тохиолдолд.

Цахилгаан бараа хэрэглэх

Хоригдлын өрөөнд VDE шалгалтаар шалгагдсан электрон барааг ашиглахыг зөвшөөрнө. Жишээ нь: Дүрдэг плитка, радио, телевиз, сахлын машин, ширээний гэрэл гэх мэт. Харин тодорхой тооны цахилгаан барааг зөвшөөрөхгүй /цахилгааны хүчдэлээс болж нэг хорих өрөөнд хэдэн цахилгаан бараа хэрэглэх нь хязгаарлагдана/. Тусгай цахилгаан барааны мэргэжилтэн хорих газрын өгсөн үүргийн дагуу цахилгаан эд барааг шалгаж лацдана. Гарах зардлыг хоригдол хариуцана.

Захидал

Таны захидал илгээж явуулах, авах тооны хязгаарлалт байхгүй. Хорих газар танд маркийг олж өгч чадна. Захидал явуулахдаа тарифинд заагдсан марк наах ёстой. Хэнд явуулж байгаагаа тодорхой

бичих хэрэгтэй. Таны хүсэлтийн дагуу хорих газраас захидал бичихэд тусалж болно. Ирэх болон явж байгаа захиал шалгана. Явуулж байгаа захидлуудыг шалгалтанд өгөхдөө дугтуйг наах ёсгүй.

Бичиг нь гаргац муутай бичсэн, нууц бичгээр бичсэн, товчилсон бичиг эсвэл гадаад хэлээр бичсэн бичиг зэрэг нь хийсэн хэрэгтэй нь холбоотойгоор материалыг зөвшөөрөлгүй бичсэн мөн хорих байгууллагын үйл ажиллагааны талаар доромжлох худал зүйл бичих, хэтрүүлэх, эсвэл ямар нэгэн гэмт хэрэг хийх төлөвлөгөө зэргийг бичсэн мөн захиагаар гэмт хэрэг хийсэн бол хууль бус тохиолдолд тооцогдоно.

Өмгөөлөгчтэй харьцах захиаг шалгахгүй, явуулж байгаа захиаг баталгаажуулж гарын үсэг зурна. Энэ захидлууд нь “өмгөөлөгчид очих шуудан гэсэн хаягтай байна”. Хүний эрхийг хамгаалдаг Европын комисс-д, тэдний гишүүдэд түүнчлэн холбооны ард түмний төлөөлөгчдөд захидал бичсэн бол шалгахгүй.

Дараах зүйлүүдийг анхаарна:

Урьдчилан хориход байгаа хүмүүсийн захидал:

Жишээлбэл: Өмгөөлөгчид очих захиаг холбогдох шүүгч эсвэл прокурор хариуцана. Харин бусад төрлийн захиаг шалгана. Гадагш нь явуулж байгаа захидлыг хангалттай маркийн хамт уутанд хийж нээлттэйгээр өгнө. Захиаг ууталсан уутан дээр дараах зүйлийг бөгөлж явуулна.

а/ нүүрэн тал

Нэр, овог нэр, төрсөн он сар өдөр, шүүхийн болон актны тэмдэглэгээ, прокуророос шалгах ёстой гэсэн мэдээ ирсэн тохиолдолд прокурорын тусгай тэмдэглэгээг бичнэ.

в/ ар тал

Хүлээн авагчийн нэр хаяг, та захианы дугтуй маркуудыг хийгээрэй, хэрвээ уутны хаяг бүрэн гүйцэт хаяглаагүй бол захиа удаашрах болно.

Холын ярна

Зайлшгүй чухал үед холын дуудлагыг зөвшөөрнө /амин чухал/. Эргэлтэнд мөрдөгддөг дүрэм журам холын дуудлаганд нэгэн адил хамаарна, холын дуудлагын үнийг өөрөө төлнө.

Илгээмж хүлээн авах

Та тасгийн ажилтнаас илгээмжтэй холбоотой марк болон маягтыг хүлээн авна. Ирсэн илгээмжинд хориглосон зүйл байгаа бол илгээмжийг буцаах зардлыг та төлөх болно.

Чөлөөт цаг

Та хорих газраас зохион байгуулж буй чөлөөт цагт зориулсан үйл ажиллагаанд цагаа үр бүтээлтэй өнгөрүүлэх боломжийг авч чадах болно.

Номын сан

Хорих газрын номын сангаас 7 хоног бүр хангалттай ном авч хэрэглэж болно. Тасгийн ажилтнаас номын катологи авч, ном зээлж болно. Герман хэлийг сайн мэддэггүй хүмүүст зориулсан ном байдаггүй. Тасаг бүрийн ханы самбарт 7 хоног бүрийн ном солилцох цагийн хуваарь гарсан байна. Зээлсэн номоо цаг хугацаанда буцааж өгөх

болон номын сангийн дотоод журмыг анхаарах хэрэгтэй.

Спорт

Спортын багуудад тогтмол оролцон хичээллэх боломжтой. Хэзээ, хаана явагдахыг чанга яригчаар зарлаж мэдэгдэх ба мөн ханын самбараас харж болно.

Чөлөөт цагаа зохицуулах

Чөлөөт цагийн хөтөлбөрт өдөр бүр 14.00 цагаас хамрагдах боломжтой. Хэрвээ та сонин захиалахтай холбоотой холбогдох дүрэм, журмыг уншаад хүлээн зөвшөөрсөн тохиолдолд сонин, сэтгүүлийг хувийн мөнгөөр захиалж болно. Сонины захиалга өгөх болон цуцлах ажилд та өөрөө хариуцлага хүлээх ёстой. Чөлөөт цагийн үйл ажиллагаанд өөрийн төлөвлөгөөний дагуу оролцоно.

Уулзалтын багцуд

Нийгмийн ажлын алба нь хар тамхины эсрэг зөвлөгөө өгөх ажлыг хариуцана. ДОХ-той хүнд туслах болон Архидан согтууруулахтай тэмцэх бүлгийн уулзалтанд хамрагдах боломжтой. Мөн “Шайдевер” нийгэмлэгийн явуулж буй бүлгийн болон сүмийн уулзалтанд хамрагдаж болно. Лалын шашинтай хүмүүс тухайн шашны бүлэгт хамрагдаж болно.

Сүмийн цуглаан

Та Ням гараг болон баярын өдрүүдэд цуглаанд очиж болно. Та сүмийн ламд сэтгэл зүйн болон хувийн асуудлаар хандан асарч халамжуулж болно.

Хорих өрөөний эд хогшил

Та өрөөний эд хогшлын бүрэн бүтэн байдлыг шалган, гэмтэл гарсан тохиолдолд нэн даруй мэдэгдэнэ, харин нуун дарагдуулсан тохиолдолд хариуцлага тооцно. Та өрөөгөө зохих хэмжээнд тохижуулж болно гэхдээ хэт их тавилгаар дүүргэх ёсгүй. Мөн өрөөний үндсэн тавилга өөрчлөгдөх ёсгүй. Зургийг жаазанд хийж тогтоох эсвэл ширээ болон тавиур дээр тавьж болно. Хана, хаалга болон бусад эд хогшил дээр юм наах, зурах, бичихийг хориглоно.

Амралт болон чөлөөгөөр гарах

Тасгийн дарга амралт болон чөлөөтэй холбоотой асуудлыг хариуцдаг. Амралт /анги дотроо/, чөлөө нь Эрүүгийн хуульд заасны дагуу олгогдоно.

Нийгмийн халамж

Та хувийн асуудлаа шийдвэрлүүлэхээр хорих газраас нийгмийн халамж тусламж хүсэж болно. Тухайн тусламжаар дамжуулан ар гэрийнхэндээ өөрийн данснаас мөнгө шилжүүлэх, хадгалуулах болон бусад төрлийн тусламж үзүүлж болно.

Урьдчилан мэдэгдэх болон гомдол гаргах

Та хорих ангийн дарга болон бусад ажилтнуудад өөрт тулгарсан асуудлын талаар гуйлт хүсэлт, гомдол гаргаж болно. Гэхдээ юуны түрүүнд тасгийн ажилтанд хандана уу. Тэр ажилтан нь таны ямар хэрэгт, ямар албан тушаалын хүн хамаатай болохыг зөвлөж өгөх болно. Хорих ангийн дарга нь 7 хоногийн Мягмар гараг бүрт уулзалтын цагтай байдаг. Гэхдээ ангийн дарга өөрөө эсвэл хэн нэгэн хүнд үүрэг даалгавар өгч, таны ямар учраас уулзах гэж байгааг тодруулна. Ангийн дарга байхгүй

тохиолдолд төлөөлөгч болох дэд дарга уулзана. Түүнээс гадна урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр /хяналтын/ албаны төлөөлөгчтэй уулзаж болно.

Гомдол гаргах

Хэрвээ хорих газрын даргын эсрэг гомдол гаргаж байгаа тохиолдолд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга шийдвэрийг гаргана. Энэ шийдвэрийг тус мужийн Хууль зүйн яамны сайд давхар хянаана.

Эсэргүүцэл

Хорих газрын ажилчдын явуулж байгаа үйл ажиллагааг эсэргүүцсэн гомдол гаргаж болно. Энэхүү эсэргүүцлээ холбогдох албан тушаалтанд бичгээр гаргана. Ямар нэгэн авсан арга хэмжээг эсэргүүцэж байгаа гомдлоо 7 хоногийн дотор тавина. Энэхүү эсэргүүцлийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын даргад тодорхой хугацаанд мэдэгдэнэ. Эсэргүүцэлийг авч хэлэлцэхдээ хэзээ ирсэн гэдгээс нь шалтгаалж, тодорхой хугацаанд асуудлыг шийдвэрлэнэ.

Зөвлөл

Тус ангийн зөвлөлд хувийн асуудлаар хандаж болно. Зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүнийг тасгийн ажилтнаас асуух болон ханы самбараас харж болно.

Зөвлөгөө: Энэ зөвлөлд бүх өргөдөл саналаа нээлттэйгээр бичгээр өгч болно. Өөрийн овог нэр, төрсөн он сар, өдөр, хувийн дугаар болон хоригдол эсвэл сэжигтэн эсэхээ бичиж явуулна.

Анхаарах зүйлүүд

- Хоригдлууд цонхоор хашгирч, холбоо тогтоохыг хориглоно.
- Эд зүйлс гадагш шидэх, нааш цааш солилцох, өгөх авахыг хориглоно.
- Цонх болон сараалжин торыг битүү зүйлээр хаахыг хориглоно.
- Өрөөний гэрэлтүүлгийг цаас болон цонхны хөшгөөр битүүлэхийг хориглоно.
- Хаалганы дуранг хаахыг хориглоно.
- Цахилгаан болон сантехникийн эд зүйлсээр оролдох, жорлон болон угаалтуур дээр зогсохыг хориглоно.
- Лазнуудыг оролдох онгойлгож болохгүй.
- Үзүүртэй хадаас болон дэгээгээр хана, тавилга зэргийг гэмтээхийг хориглоно.
- Хорих байранд сэлгүүлцэх, зөвшөөрөгдөөгүй шатыг ашиглах ёсгүй
- Шөнийн амар тайван байдлыг алдагдуулж болохгүй.
- Таны хувийн хэрэгцээнд өгсөн эд зүйлсийг гуравдагч этгээдэд өгөхийг хориглоно.

Дотоод журам зөрчсөн тохиолдолд Эрүүгийн хууль болон урьдчилан хоригдогчдын мөрдөх дүрэм журмын дагуу сахилга батын арга хэмжээ авна. Эсвэл шүүхэд хэрэг мэдүүлж, хэргийг шийдвэрлүүлнэ. Хууль, дүрэм зөрчснөөс гарсан хохирол зардлыг нөхөн төлүүлэх арга хэмжээг авна.

Орчуулан бэлтгэсэн: О.Пүрэвсүрэн
Г.Туул